ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Д.ЖАРГАЛСАЙХАНЫ
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.** “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах” | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангахтай холбоотой Монгол Улсын авсан үүрэг амлалтыг биелүүлэх, Дэлхийн худалдааны байгууллагаас Монгол Улсын Худалдааны бодлогыг хянасан 2021 оны дүгнэлтийн хэрэгжилтийг хангах | Эхний хагас жил:- Онош зүйн шинжилгээний тайланд тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах БДШалгалт хийх журам, зааврыг шинэчлэн батлуулахаар төслийг бэлтгэн холбогдох хэлтэс, газраар хянуулсан байна.<br>Албан хаагчдыг чадавхжуулах сургалтад хамруулна.<br>Сүүлийн хагас жил: - БДШ хийх журам, зааврыг шинэчлэн батлуулсан байна.<br>ДГБ-ын олон улсын сургалтад албан хаагдыг хамруулсан байна. | Дэлхийн худалдааны байгууллагын худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн зүйл 7.5 бүрдүүлэлтийн дараах шалгалт арга хэмжээний хэрэгжилт<br>- Дэлхийн гаалийн байгууллагын “Меркатор” хөтөлбөр болон Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чадавхыг бэхжүүлэх онош зүйн шинжилгээг 2022 онд хийж, тайланд тусгасан зөвлөмжийг Гаалийн ерөнхий газрын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн төлөвлөгөө болон 2023, 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангах ажиллаж байна.<br>- 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Гаалийн ерөнхий газарт зохион байгуулагдсан ОУВС-ын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтад оролцсон.<br>Онош зүйн шинжилгээний тайланд тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах БДШалгалт хийх журам, зааврыг шинэчлэн батлуулах дараах ажлыг хийсэн. Үүнд:<br>Бүрдүүлэлтийн дараах шалгалтын эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр ДГБ-ын экспертүүдийн тусламжтайгаар Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам, Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх зааврын шинэчлэн | 2024.01.01<br>2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | найруулсан төслийг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.<br>- Бүрдүүлэлтийн дараах шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч нарыг мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр ДГБ-ын бүрдүүлэлтийн дараах шалгалт, барааны гарал үүслийн сургалт, мөн Олон улсын валютын сангаас зохион байгуулсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх сургалтад тус тус хамруулсан.<br>- Бүрдүүлэлтийн дараах шалгалтын албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэхээр Япон улс, Токио хотод ДГБ, Япон улсын Гаалийн байгууллагын хамтран зохион байгуулсан сургалтад БДШГ-ын 7 албан хаагч хамрагдсан.<br>- Бүрдүүлэлтийн дараах шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч нарыг мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр тэдгээрт зориулсан тусгайлсан сургалтын хөтөлбөрийг боловсруулахаар ажиллаж байна.<br>- Эрсдэлийн удирдлагад суурилсан бүрдүүлэлтийн дараах шалгалтыг төлөвлөх, зохион байгуулах үйл ажиллагаа автоматжуулах зорилгоор гаалийн бүрдүүлэлтийн өргөтгөл системийг боловсруулан үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.<br>- БДШГ-ын нэг ажилтан Дэлхийн гаалийн байгууллагын бүрдүүлэлтийн дараах шалгалтын техникийн болон үйл ажиллагааны итгэмжлэгдсэн экспертийн эрх авах болзол хангасан.<br>Албан хаагчдыг чадавхжуулах дээшлүүлэх 11 удаагийн сургалтад хамрагдсан. дэлгэрэнгүй тайланг хавсаргав | | |
| 2. | Мэдээлэлд эрсдэлийн судалгаа хийж, мэдээллийн | Хэрэгжилт гүйцэтгэлээр | Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг | Эхний хагас жилд:<br>1.Эрсдэлийн судалгаа хийсэн байна.<br>2.Судалгааг үндэслэн шалгуур үзүүлэлтийн | 1. Эрсдлийн санд эхний хагас жилийн байдлаар шинэчилсэн БДШ-ын системд ГЕГ-ын ЭУХ-ээс ирүүлсэн 298 ААН, БАУХ-ээс ирүүлсэн 45 ААН, АТГ болон ЦЕГ-ын ЭЦГ зэрэг хуулийн байгууллагаас ирүүлсэн 3 ААН, | 2024.01.01<br>2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бааз баяжуулсан байдал | | хөнгөвчлөх хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг хангахтай холбоотой Монгол Улсын авсан үүрэг амлалтыг биелүүлэх, Дэлхийн худалдааны байгууллагаас Монгол Улсын Худалдааны бодлогыг хянасан 2021 оны дүгнэлтийн хэрэгжилтийг хангах | дагуу мэдээллийн санд өөрчлөлт оруулсан байна. 3.Мэдээллийн санд оруулсан мэдээллийг бүрдүүлэлтийн дараах шалгалтанд ашигласан байна.<br>Сүүлийн хагас жилд:<br>1.Эрсдэлийн судалгаа хийсэн байна.<br>2.Судалгааг үндэслэн шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийн санд өөрчлөлт оруулсан байна. 3.Мэдээллийн санд оруулсан мэдээллийг бүрдүүлэлтийн дараах шалгалтанд ашигласан байна. | ЧХОУНБГГ-аас ирүүлсэн 52 ААН, ЗҮГГ-аас ирүүлсэн 29 ААН, 2023 онд шалгагдахаар удирдамж батлагдсан боловч шалгалт хойшлогдсон 1 ААН буюу нийт 428 ААН-ийн мэдээллийг эрсдэлийн мэдээлэл судалгаатай ААН бүрээр БҮРТГЭЛИЙН САН-д бүртгэж 428 эрсдэлтэй ААН-ийн санг бүрдүүлэн ажилласан. Үүнд: Эрсдлийн мэдээллийг 5 албан тоот, 14 дотоод зурвасыг үндэслэн нотлох баримтаар эрсдэлийн судалгааг бүртгэсэн.<br>2. Судалгааг үндэслэн шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийн санд өөрчлөлт орсан байдал. Үүнд:<br>- БДШ-ын шинэ системээр "Төлөвлөгөөт шалгалтын сан"-д 64 ААН-ийн шалгалтыг үүсгэсэн бөгөөд нийт 9 шалгуураар программаар төлөвлөн 32 ААН-д бүрдүүлэлтийн дараах шалгалтын удирдамж батлуулсан бөгөөд 16 ААН-ийн шалгалт дуусаж, 1 ААН-ийн шалгалт хийгдээгүй, 13 ААН-ийн шалгалт үргэлжлэн хийгдэж байгаа, 2 ААН-ийн шалгалт хойшлогдсон байна. Төлөвлөгөөт шалгалтаар дууссан нийт 16 шалгалтыг зөрчлийн байдлаар ангилавал 87,5 хувь буюу 14 ААН-д зөрчил илэрсэн, 12,5 хувь буюу 2 ААН- д зөрчил илрээгүй байна.<br>- БДШ-ын шинэ системээр "Төлөвлөгөөт бус шалгалтын сан"-д 18 ААН-ийн шалгалтыг үүсгэн бүрдүүлэлтийн дараах шалгалтын удирдамж батлуулсан.<br>Тус төлөвлөгөөт бус шалгалтад хамрагдсан 16 ААН-ийн шалгалт дуусаж, 1 ААН-ийн шалгалт үргэлжлэн хийгдэж байгаа, 1 ААН-ийн шалгалт хойшлогдсон байна. Төлөвлөгөөт бус шалгалтаар дууссан нийт 16 шалгалтыг зөрчлийн байдлаар ангилавал 62,5 хувь буюу 10 ААН-д зөрчил илэрсэн, 37,5 хувь буюу 6 ААН- д зөрчил илрээгүй байна.<br>3. Мэдээллийн санд оруулсан мэдээллийг бүрдүүлэлтийн дараах шалгалтанд ашигласан байдал. Үүнд: | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Төлөвлөгөөт шалгалтын санд эхний хагас жилд БДШ-д хамрагдах ААН-үүдийг нэгжийн улирал, сарын төлөвлөгөөтэй уялдуулан ААН-үүдийн тоог төлөвлөн нэмэлт 4 тусгай шалгуураар буюу импортын төрөл, эрсдэлийн ногоон төлөвөөр гаалийн бүрдүүлэлт хийгдсэн, БДШ ороогүй, бусад гаалийн зөрчлийн мэдээлэлтэй зэрэг эрсдэлийн нийт 9 шалгуураар санг үүсгэсэн 32 ААН-ийн удирдамж батлагдсан.<br>-Төлөвлөгөөт бус шалгалтын санд эрсдлийн шалгуураар үүссэн 18 ААН-д удирдамж батлагдсан. | | |
| **Зорилт 2.** "Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх" | | | | | | | |
| 1. | Бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх, гарсан үр дүн | Бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулсан аж ахуйн нэгжийн тоо, Бүрдүүлэлтийн дараах шалгалтаар улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн, төгрөгөөр | Гадаад худалдаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллагад эрсдэлийн удирдлагад суурилсан бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийх | Эрсдэлийн удирдлагад суурилсан төлөвлөгөөт БДШ хийсэн ААН-ын тоо, иргүүлсэн нөхөн төлбөр, шийтгэлийн дүн өмнөх оны суурь түвшнээс 3-аас доошгүй хувиар өссөн байна.<br>Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны А/122 тоот тушаалаар 5.1 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлэхээс: Эхний хагас жилд: 50 ААН-д бүрдүүлэлтийн дараах шалгалт хийж, 500 сая төгрөг, Сүүлийн хагас жилд: 93 ААН-д бүрдүүлэлтийн дараах шалгалт хийж, 4,7 тэрбум төгрөг 2024 онд нийт 143 аж ахуйн нэгж, байгууллагад бүрдүүлэлтийн дараах шалгалт хийж, үнэлэлт, | Эхний хагас жил 2024 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн байдлаар өмнөх оны 8 ААН болон тайлант хугацаанд нийт 64 ААН-д бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх удирдамж батлагдсан байна. Үүнд:<br>Үүнээс 45 ААН-ийн шалгалтын үр дүнгээр 21,2 тэрбум төгрөгийн зөрчлийг илрүүлж 3,33 тэрбум төгрөгийн нөхөн татвар , торгуулийг ногдуулсан. үүнээс<br>- Бүрдүүлэлтийн дараах шалгалтын үр дүнгээр 38 ААН-д холбогдох 9,1 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 2,1 тэрбум төгрөгийн нөхөн татвар, 476,2 сая төгрөгийн торгуулийг ногдуулж Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэн 1,37 тэрбум төгрөгийн нөхөн татвар, торгуулийг улсын төсөвт төвлөрүүлж, 717,5 сая төгрөгийн нөхөн татвар, торгууль хугацаандаа төлөгдөхөөр хүлээгдэж байна.<br>- Бүрдүүлэлтийн дараах шалгалтын үр дүнгээр 7 ААН-д холбогдох холбогдох 12,1 тэрбум төгрөгийн зөрчлийн дүнтэй хохирол нь 2,1 тэрбум төгрөгийн нөхөн татварыг төлөхөөс зайлсхийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэлийг илэрүүлсэн.<br>Тайлант хугацаанд 10 аж ахуйн нэгжид хийсэн шалгалтын үр дүнгээр ямар нэгэн зөрчил илрээгүй, 14 аж ахуйн нэгжийн шалгалт үргэлжилж байна. ГЕГ-ын ЭУХ-ээс | 2024.01.01<br>2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дүгнэлт өгөн, илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж, улсын төсөвт 5.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна. | 5 дотоод зурвасаар ирүүлсэн 52 ААН, ЗТГ-азраас 2 ААН, БАУХ-ээс 4 дотоод зурвасаар ирүүлсэн 2 ААН, БДШ-ын программд 9 эрсдлийн шалгууруудаар сонгогдон шалгалтад хамрагдсан байна.<br>- Эрүүгийн Цагдаагийн газраас ирүүлсэн хүсэлтээр 1 ААН,<br>- Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2 ААН,<br>- ЗҮГГ-аас ирүүлсэн 3 ААН,<br>- ЧХОУНБГГ-аас ирүүлсэн 2 ААН,<br>ААНБ-ын нууцтай холбоотой тул файл хавсаргаагүй болно. | | |
| 2. | Шүүхээр шийдвэрлэгдсэн зөрчил | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Эхний хагас жил: - Төрийн болон хууль хяналтын байгуулагатай хамтран ажилласан байна. Бүрдүүлэлтийн дараах шалгалтаар илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, холбогдох арга хэмжээг авсан байна.<br>Сүүлийн хагас жил: - Төрийн болон хууль хяналтын байгуулагатай хамтран ажилласан байна.<br>- Бүрдүүлэлтийн дараах шалгалтаар илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, холбогдох | Эхний хагас жилд нийт 7 ААН-д холбогдох татвараас зайлсхийх гэмт хэргийн шинжтэй 12,1 тэрбум төгрөгийн зөрчлийн үнийн дүнтэй 2,1 тэрбум төгрөгийн нөхөн төлөгдөх хохиролын дүнтэй хэргийг илрүүлж холбогдох эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн. Үүнд:<br>1.Татвар болон хууль хяналтын байгууллагатай хамтран ажилласан байдал:<br>- Авилгатай тэмцэх газраас ирүүлсэн 1 иргэнд холбогдох 5,4 сая төгрөгийн зөрчилд холбодох 2,1 сая төгрөгийн татвар, 1 ААН-д холбогдох 166.1 сая төгрөгийн зөрчилд холбогдох 38,6 сай төгрөгийн татвар, торгуулийг шалгалтын үр дүнгээр илрүүлсэн зөрчлийг баримтаар нотлон хүргүүлсэн.<br>2.Хууль хяналтын байгууллагатай хамтарсан болон гомдол мэдээллийн дагуу хийгдсэн төлөвлөгөөт бусшалгалт үр дүнгээр нийт 18 ААН-д шалгалт хийсэн. 1.8 тэрбум төгрөгийн зөрчилд 367,5 сая төгрөгийн өнхөн татвар торгууль ногдуулж барагдуулсан.Тагнуулийн Ерөнхий газарт шалгагдаж байгаа 2 ААН. ГЕГ- ын даргын баталсан 2ААН-д удирдамжийн хүрээнд шалгалт хийх боломжгүй хойшлогдсон<br>3. Шүүхийн шийдвэрийн үр дүн. Тайлант хугацааанд 5 ААН-д холбогдох шүүх | 2024.01.01<br>2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | арга хэмжээг авсан байна. | хуралд оролцсон. Захиргааны хэргийн шүүхэд 2 ААН-д 351,5 сая төгрөгийн нөхөн татвар, торгуулийн шилжүүлэн шүүх хурлын тов хүлээгдэж байгаа.<br>Шүүхийн шийдвэрээр 8 ААН-ийн 251.1 сая төгрөгийн барагдуулалт хийгдсэн.<br>4. Цагдаагийн байгуулагад шилжүүлсэн шалгалтын үр дүнтэй холбоотой шийдвэр гарч, холбогдох арга хэмжээ авсан байдал: 2023 оны шалгалтын үр дүн болон энэ оны эхний хагас жилийн байдлаар Цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгагдаж байгаа 11 ААН-ээс 1 ААН-д холбогдох гэмт хэргийн шинжтэй биш тул хэрэг үүсгээгүй 251,6 сая төгрөгийн зөрчил Прокурорын тогтоолоор Гаалийн байгууллагад шилжин ирсэн. Үүнд:<br>- ЭЦА-ны ЭЗАлбанд 8 ААН-ийг шилжүүлсэн 3,8 тэрбум төгрөгийн зөрчилд холбогдох 812,7 сай төгрөгийн хохирол<br>- СБ ЦХэлтэст 2 ААН-ийг шилжүүлсэн 47.3 төгрөгийн зөрчилд холбогдох 7,3 тэрбум төгрөгийн хохирол<br>- ЧД-ийн ЦХэлтэст 1 ААН-ийг шилжүүлэн 569,8 сай төгрөгийн зөрчилд холбогдох 88,3 сая төгрөгийн хохиролын материалыг хүргүүлсэн шалгагдаж байгаа.<br>- Нийслэлийн Прокурорын газрын удирдах ажилтаны зөвлөгөөн 2024.02.27-д зохион байгуулагдсанд БДШГазраас оролцон"БДШалгалтын үр дүнгээр илэрч буй зөрчил дутагдлыг арилгах, цаашид улсын хилээр оруулж байгаа барааны хяналтыг сайжруулах зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих, зөрчлийг арилгах" сэдвээр БЦТөвд 01/2024 тоот чиглэл хүргүүлж үр дүнг тооцсон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Нөхөн төлбөрийн авлагын барагдуулалт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Эхний хагас жил: - Бүрдүүлэлтийн дараах шалгалтаар үүссэн өр авлагыг барагдуулж, нөхөн төлбөр, шийтгэлийг хугацаанд нь барагдуулан үлдэгдэлгүй байна.<br>-ААНБ-аас ирүүлсэн нөхөн татвар, торгууль хэсэгчлэн төлөх тухай хүсэлтийг хүлээн авч, хяналт тавьж ажиллана.<br>Сүүлийн хагас жил: - Бүрдүүлэлтийн дараах шалгалтаар үүссэн өр авлагыг барагдуулж, нөхөн татвар, шийтгэлийг хугацаанд нь барагдуулан үлдэгдэлгүй байна.<br>-ААНБ-аас ирүүлсэн нөхөн татвар, торгууль хэсэгчлэн төлөх тухай хүсэлтийг хүлээн авч, хяналт тавьж ажиллана. | Өмнөх онуудаас үүссэн өр, авлагыг барагдуулах чиглэлээр 2024.03.01- ын өдөр ажлын хэсэг 4 төлөвлөгөөг батлаж ажилласан.<br>1. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт байгаа өр авлагыг барагдуулах ажлын хүрээнд: Тус ажлын хүрээнд. бүрдүүлэлтийн дараах шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг бүх шатны шүүхээр шийдвэрлүүлж нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэн дараах ААН-үүдын төлбөрийг графикаар төлүүлж байна. Үүнд: ХХК, ХХК, ХХК, ХХК, ХХК<br>Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт нийт 14 удаа албан тоот хүргүүлэн графикаар төлөгдөж байгаа ААН-үүдийн өр төлбөрийн үлдэгдэлийг Төрийн сангийн тоот дансруу шилжүүлж шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгож өгөх хүсэлт гаргасан.<br>2. Шүүхтэй холбоотой өр барагдуулах чиглэлээр : ХХК, ХХК зэрэг 2 ААН шүүхийн шатанд явж байна. Энэ 2 компани дээр нийт 4 удаагийн шүүх хурал зарлагдсан боловч тодорхой шалтгаануудаар хойшлогдсоор байна.<br>3. Хаяг, байршил тодорхойгүй иргэн, аж ахуй нэгжийг төрийн бусад байгууллагуудтай холбогдон зохих арга хэмжээ чиглэлээр: Хаяг, байршил тодорхойгүй нийт 27 иргэн, аж ахуй нэгжийг улсын бүртгэлийн ерөнхий газарт албан тоот хүргүүлэн иргэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагааг аван төрийн бусад байгууллагуудтай холбогдон удаа дараа утсаар болон тухайн хаяг ан дээрх байгаа газарт биечлэн очиж ажилласан.Гэвч улсын бүртгэлтэй хаяган дээрээ байдаггүй зарим ААН нь утсаа авахгүй байгаа нь ажил явуулахад хүндрэлтэй байсан. | 2024.01.01<br>2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. Бусад өр авлагыг барагдуулах чиглэлээр: Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн газарт албан тоот явуулж, ААН-ын хаягийн мэдээллийг авч биечлэн очсон боловч тухайн хаяган дээрээ байдаггүй байршил тодорхойгүй, олдохгүй байсан тул эрэн сурвалжилах тогтоол гаргуулахаар шүүхэд хандсан ч ААН-үүд олдоогүй.<br>Өмнөх оны 2010-2023 оны нийт 29 ААН-ээс 8,6 тэрбум төгрөгийн өр авлага үүссэн. Тайлант хугацаанд 8 ААН-ийн 251.1 сая төгрөгийг барагдуулалтийг хийж 4 ААН-иын авлага бүрэн дууссан .<br>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон графикаар төлж байгаа 4 ААН-ын 2.2 тэрбум төгрөг,<br>- шүүхийн шатанд байгаа 5 ААН-ын 4.8 тэрбум төгрөг,<br>- хаяг байршил тодорхойгүй, олдохгүй байгаа 18 ААН-ийн 1.3 тэрбум төгрөгийн өр авлагатай иргэн, ААН- үүд байна. | | |
| 4 | Гаалийн нөхөн бүрдүүлэлт | Хэрэгжилт гүйцэтгэлээр, хувиар | | Гаалийн нөхөн бүрдүүлэлт хууль, журмын дагуу үнэн зөв хийгдэж, улсын төсөвт оруулсан мөнгөн дүн өмнөх оны суурь түвшнээс 5- аас дээш хувиар өссөн байна.<br>Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны А/122 тоот тушаалаар 1,5 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлэхээс:<br>- Эхний хагас жил: Улсын төсөвт 700 сая төгрөгийг гаалийн нөхөн бүрдүүлэлтээр улсын | Улсын төсөвт 700 сая төгрөгийг гаалийн нөхөн бүрдүүлэлтээр улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн.<br><br>-Нөхөн бүрдүүлэлтээр 2023 оны 12 дугаар сарын 1-ээс 2024 оны 06 дугаар сарын 21-ний хооронд 70 ААН- ийн 201 ширхэг бараанд гаалийн нөхөн бүрдүүлэлт хийлгэх хүсэлт, дагалдах бичиг баримтыг үндэслэн 234 гаалийн мэдүүлгээр, 8,570.9 сая ам доллар бүхий, суурь үнэ 29,240,3 сая төгрөгийн бараанд гаалийн нөхөн бүрдүүлэлт хийж 4,532.2 сая төгрөгийн гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, 1,8 сая төгрөгийн хураамж нийт 4,534.1 сая төгрөгийн татвар, хураамжийг улсын төсөвт төвлөрүүлсэн.<br><br>-Өмнөх оны хагас жилтэй харьцуулбал 109 хувиар давуулан биелүүлсэн байна. Нөхөн бүрдүүлэлтийн мэдээг файл хэлбэрээр хавсаргав. | 2024.01.01<br>2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төсөвт төвлөрүүлсэн байна.<br>- Гаалийн нөхөн бүрдүүлэлт хууль журмын дагуу үнэн зөв хийгдсэн байна. Сүүлийн хагас жил:<br>- Улсын төсөвт 800 сая төгрөгийг гаалийн нөхөн бүрдүүлэлтээр улсын төсөвт төвлөрүүлсэн байна.<br>- Гаалийн нөхөн бүрдүүлэлт хууль журмын дагуу үнэн зөв хийгдсэн байна. | | | |
| 5 | Бүрдүүлэлтийн дараах шуурхай шалгалтыг зохион байгуулсан байдал | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Эхний хагас жил: - Төлөвлөгөөт бус шуурхай шалгалтыг зохион байгуулж, зөрчил илрүүлэлт нэмэгдсэн байна.<br>Сүүлийн хагас жил: Төлөвлөгөөт бус шуурхай шалгалтыг зохион байгуулж, зөрчил илрүүлэлт нэмэгдсэн байна./I-IV улирал/ | БДШуурхай шалгалтыг ГЕГ-ын бүтцийн нэгж, Эрх бүхий холбогдох байгууллагын ирүүлсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус шалгалтын санг бүрдүүлж шуурхай шалгалтыг зохион байгуулж нийт 18 ААН-д ГЕГ-ын даргын БДШ хийх удирдамж батлагдсан.<br>БДШуурхай шалгалтад 16 ААН-ийн шалгалт дуусаж, 1 ААН-ийн шалгалт үргэлжлэн хийгдэж байгаа, 1 ААН-ийн шалгалт хойшлогдсон байна. Үүнд:<br>- ГЕГ-ын ЭҮХ-ээс 3 дотоод зурвасаар ирүүлсэн 11 ААН, ЭҮХ-ийн 2024.04.08-ний өдрийн 2024/63 тоот дотоод зурвасаар ирүүлсэн 7 ААН-ийг эм эмнэлэгийн хэрэгслийн УИХ-ын сонсголтой холбоотой цаг үеийн шинжтэй төлөвлөгөөт бус шалгалт,<br>- БАҮХ-ээс 2 дотоод зурвасаар ирүүлсэн 2 ААН, ГЕГ-ын БАҮХ-ийн 2024.01.25-ний өдрийн 02-2.1/18 дотоод зурвас,<br>- Авлигатай тэмцэх газраас 1 иргэн, 1 ААН-ийг шалгах хүсэлт ирүүлсэн. АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэсийн 2024-02-15-ны өдрийн 06/2955 тоот. | 2024.01.01<br>2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - ЦЕГ- ЭЦГ-аас 3 албан тоотоор ирүүлсэн 3 ААН шалгалтад хамрагдсан байна. ЦЕГ-ЭЦА 2024.01.08-ний өдрийн 10а-1/348 албан тоот.<br>- Шудрага өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2024.01.15-ний өдрийн 01-47 тоот албан тоот, Бүрдүүлэлтийн дараах шуурхай шалгалтын үр дүнгээр 10 ААН-д зөрчил илэрч 1,8 тэрбум төгрөгийн зөрчилд 367,5 сая төгрөгийн нөхөн татвар, 144,6 сая төгрөгийн торгууль нийт 420,7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. | | |
| **Зорилт 3.** "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх" | | | | | | | |
| 1. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Эхний хагас жил: - "Бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулж холбогдох нэгжээр хянуулсан байна.<br>- Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажилласан байна.<br>Сүүлийн хагас жил:<br>-"Бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам", зааврыг батлуулсан байна. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийн биелэлт гарган хүргүүлсэн байна.<br>- Холбогдох дүрэм, журамд санал хүргүүлсэн байна. Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажилласан байна. | ГЕГ-ын даргын 2015 оны 135 болон 2022 оны 344 тоот тушаалаар тус тус батлагдсан "Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам" болон "Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх заавар"- ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр холбогдох материалыг хүргүүлэн МЗХурлаар 2024 оны 06-р сарын 14-д 06/04-ны хурлаар хэлэлцүүлсэн.<br>Энэ ажлын хүрээнд 2024 оны эхний хагас жилд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:<br>Шинэчлэн найруулсан төсөлтэй холбоотойгоор ГЕГ-ын нийт 18 ЗББНДБ, гаалийн газар, хорооноос ирүүлсэн саналыг нэгтгэж, саналыг нэгбүрчлэн газраараа хэлэлцэж, шийдвэрлэсэн;<br>Төсөлтэй холбоотойгоор ДГБ-ын экспертүүдээс ирүүлсэн 10 хуудас зөвлөмжийг орчуулж, | 2024.01.01<br>2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын хамт олон танилцуулж, хэлэлцүүлсэн;<br>Журам, зааврын төслийг газрын хэмжээнд 2024 оны 02 дугаар сард 2 удаа, 03 дугаар сард 2 удаа, нийтдээ 4 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан;<br>Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журмын шинэчилсэн найруулгын төсөлд санал авахаар Дотоод зурвасаар Олон нийттэй харилцах албанд хандаж, 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Гаалийн байгууллагын цахим хуудаст байршуулсан;<br>Журам, зааврын шинэчилсэн найруулгын төслийг 2024 оны 04 дүгээр сар болон 05 дугаар сард нийтдээ 2 удаа Дотоод зурвасаар Хуулийн хэлтэст хүргүүлж, хянуулсан;<br>Журам, зааврын шинэчилсэн найруулгын төслийг Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, холбогдох танилцуулга (Word, Powerpoint)-ыг бэлтгэж, Захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.<br>Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудлыг эцэслэн Хууль зүйн яаманд хүргүүлэхээр 2024.06.25-ны өдрийн 123/24 тоот дотоод зурвасаар Хуулийн хэлтэст хүргүүлсэн. | | |
| 2. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | "Бараа бүртгэлийн нэгдсэн систем" бүрэн ашиглалтад орсны дараа гаалийн мэдүүлэг тус бүрээр барааны борлуулалтын мэдээг авч, | ББНС-ээс мэдээлэл авч БДШ-тад ашиглаж болох талаар Татварын ерөнхий газрын ЭУГ, УУМТТ-тэй 2 удаа уулзалт хийсэн.<br>- БДШГ-т ББНС-д нэвтрэх эрх олгосон боловч мэдээллийг | 2024.01.01<br>2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гаалийн хяналт шалгалт болон бүрдүүлэлтийн дараах шалгалтад ашиглаж, илрүүлсэн зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна.<br>Бараа бүртгэлийн нэгдсэн систем" бүрэн ашиглалтад орсны дараа гаалийн мэдүүлэг тус бүрээр барааны борлуулалтын мэдээг авч, гаалийн хяналт шалгалт болон бүрдүүлэлтийн дараах шалгалтад ашиглаж, илрүүлсэн зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна. | шалгалтад ашиглах боломжгүй байгаа тул цаашид хэвийн болгуулах талаар уулзалт хийсэн.<br>- Одоогийн байдлаар БДШ-тад хамрагдсан ААН-ийн мэдээллийн санд үүссэн бар кодтой барааг тухайн ААН-ийн орлогод авсан барааны бүртгэлтэй гар аргаар тулган шалгаж байна.<br>БДШ-тад хамрагдсан ААН-ийн 45 ААН-ийн барааны бүртгэлийн 520 кодыг тулган шалгасан талаар ГУБ нараас мэдээг тухай бүрт авч ажиллаж байна.<br>Цаашид энэ ажил нь бүрэн ашиглалтад ортол гүйцэтгэх боломжгүй энэ хил дээр хяналтын үед хэрэгжүүлж "Бараа бүртгэлийн нэгдсэн систем"-д бүртгэлийн код үүсгэн мэдээллийн баазыг баяжуулах нь тохиромжтой.<br>өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16%-ийн гүйцэтгэлтэй байна. | | |
| 3. | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт хувиар | | Ажлын цаг ашиглалт 100 хувь байна. | Сангийн яамны тушаалаар ГЕГ-ын дэргэдэх байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог газрын дарга-1, ГУАБ-2, ГУБ-26-аар батлагдсан. 2024 оны хагас жилд Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар нь Газрын дарга-1, ГУАБ-2, ГУБ-21 орон тоотойгоор нийт 24 хүний бүрэлдэхүүнтэйгээр (1 байцаагч хүүхэд асрах чөлөөтэй) ажилласан.<br>-Тайлант хугацаанд эхний хагас жил 120 ажлын өдөр, 960 ажлын цаг ажиллахаас нийт 24 ажилтан 2880 хүн өдөр буюу 23040 хүн цаг | 2024.01.01<br>2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллахаас 2874 хүн өдөр, 22922 хүн цаг ажилласан байна. Үүнд : ээлжийн амралт 39 хүн өдөр буюу 312 хүн цаг, өвчтэй 6 хүн өдөр буюу 912 хүн цаг, чөлөөтэй 1 хүн өдөр буюу 40 хүн цаг ажилласан байна.<br>БДШ-д хамрагдаж буй ААНБ өөрийн ажлын байрнаас санхүүгийн баримт, мэдээг гаргах боломжгүй тохиолдолд тухайн байгууллагын ажлын байранд шалгалт хийхтэй холбоотой ГЕГ-ын даргын баталсан Удирдамжийг үндэслэн цахим бүртгэлийн системд хүсэлт илгээдэг. | | |
| 4. | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Эхний хагас жил: Удирдлагын шуурхай хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Захиргааны зөвлөлийн хуралдаан, Онлайн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна.<br>Сүүлийн хагас жил: Удирдлагын шуурхай хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Захиргааны зөвлөлийн хуралдаан, Онлайн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна. | 2024 оны эхний хагас жилд Серп программын үүрэг даалгавар хэсэгт нийт 32 үүрэг даалгавар байна. Үүнээс: Тайлант хугацаанд ЗУГазраас 2 үүрэг даалгавар "ГЕГ-ын даргын 2022 оны А/226 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 2.13 дахь заалтыг үндэслэн нийт ажилтан, албан хаагчдад зориулсан "Мэдээллийн цаг"-ийг 14 хоног тутамд 1 удаа зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. гэсний дагуу сургалтын санал хүргүүлсэн.<br>- БДШГ-аас санаачлан урьж оролцуулсан. 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит 09 цагийн "Мэдээллийн цаг"-т Чингис хааны өв соёлын хүрээлэнгийн ЭША, Энэтхэг буддын гүн ухааны багш судлаач, орчуулагч Ч.Хатанбаатар "Төрийн албан хаагчийн ёс зүй" | 2024.01.01<br>2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэдвээр нийт ГЕГ-ийн албан хаагчид мэдээлэлйг хүргэж ажилласан.<br>- "Гаалийнулсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам"-ыг нийт албан хаагчиддаа танилцуулах ажлыг шуурхай зохион байгуулж,мөн журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг үүрэг болгож энэ ажлын хүрээнд стандартын дагуу дүрэм хувцас, ялгах тэмдэг хэрэглэх талаар танилцуулж гарын үсэг зуруулан авч гүйцэтгэлийн үнэлгээнд тооцох талаар сануулсан.<br>- ХШҮДАГ-аас 2024.04.10-2024.06.03 2 зөвлөмж ирүүлсэн. ГУБ, ГУАБ, удирдлага нэгжийнхээ үйл ажиллагаанд тогтмол мониторинг хийдэг, хоцрогдож буй ажил, арга хэмжээндээ анхаардаг, энэ тухай тайлагнаж хэвших. Хөндлөнгийн хяналт шинжилгээг жилд 2 удаа нэгжийн ирүүлсэн тайлагналтад хийдэг нь хангалтгүй, яагаад гэвэл зарим ГУБ нарын хийсэн ажил нэгжийн гүйцэтгэлд орохгүй үлдэх, нэгжийн дарга гүйцэтгэл биелэлтээ дутуу оруулдаг, хянадаггүй, хайхрамжгүй ханддагаас болж бодит үр дүн гардаггүйтэй холбоотой. биелэлт Газрын хэмжээн сар бүр ГУБ, ГУАБ үйл ажиллагаанд тогтмол мониторинг хийдэг, хоцрогдож буй ажил, арга хэмжээндээ анхаарч газрын дотоод ажил үүргийн хуваарийг 2024.02.05-д батлаж нийт албан хаагчдийг жигд ажил үүрэгт хувиарлаж гүйцэтгэлийн төлөвлөгөөний | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | биелэлтийг жигд ханган ажиллаж байна.<br>-БДШГазар дотор нэгжийн эрсдлийн дотоод мониторинг хийж нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган шалгуур үзүүлэлтээр албан хаагчидаа санал авсан нийт 25 санал ирсэнээс эрэблэн тогтоож бууруулах арга хэмжээг газраараа хэлэлцэн дүн шинжилгээнд матриц хийсэн.<br>-Хугацаа болоогүй 23 зөвлөмжийн явцын бүртгэл хийж байгаа. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дуусссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. | Удирдах албан тушаалын албан тушаалын тодорхойлолт нийцсэн байна. | - Эрхэлсэн түшмэлийн сургалтад суралцаж 2024 оны 2 сард төгссөн сертификат авч мэдлэг, чадвараа нэмэгдүүлсэн. | 2024.01.01<br>2024.06.05 | 100% |
| 2 | ДГБ-ын болон гадаад, дотоодын сургалтад хамрагдах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | ДГБ-ын болон гадаад, дотоодын сургалтад Албан хаагчдыг хамруулж чадвахийг бэхжүүлэх, мэдлэг чадвараа | - Япон улсын Гаалийн байгууллагын дэмжлэгтэй туршлага судлах, мэдлэг олгох 7 хоногийн сургалтад 7 ГУБ нарыг Япон улсад 2 дугаар сард сургалтад хамруулж ирсэн албан хаагчдын сургалтын талаар нийт | 2024.01.01<br>2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дээшлүүлсэн байна. | ГУАБ, ГУБ нарт сургалт хийлгэсэн. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын дарга

Даваасамбуу овогтой Жаргалсайхан

............................
*( Нэр, гарын үсэг )*

............................
*( Огноо )*

## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГА ДАВААСАМБУУ ОВОГТОЙ ЖАРГАЛСАЙХАНЫ 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 58.9 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1 | Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад суралцаж 2024 оны 2 сард төгссөн сертификат авч мэдлэг, чадвараа нэмэгдүүлсэн. | | 13 |
| 2 | ДГБ-ын болон гадаад сургалт 11 албан хаагчидыг, дотоодын 11 сургалтад нийт 22 албан хаагчдыгхамруулж чадвахийг бэхжүүлэх, мэдлэг чадвараа дээшлүүлэхэд зохион байгуулж хамруулсан. | | 13 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 13 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1 | Хандлага, ёс зүй | 10 |
| 2 | Удирдан зохион байгуулах | 10 |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 10 |
| 4 | Манлайлах | 10 |
| 5 | Багаар ажиллах | 15 |
| 6 | Харилцаа | 15 |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | |
| 7 | Мэргэжлийн ур чадвар | 12 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 12 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 58.9 |

| | | |
|---|---|---|
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 13 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 12 |
| **Нийт оноо=** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 83,9 |

**Үнэлгээ өгсөн:** **Төсвийн шууд захирагч**

Гаалийн ерөнхий газрын дарга ............................ (Р.Отгонжаргал)

2024. 06. 19 ............................ (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Нэгжийн дарга:**

Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын дарга ............................ (Д.Жаргалсайхан)

2024. 06. 21 ............................ (огноо)